



**ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО**

Ж.Самбуугийн гудамж-30, Бага тойруу,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14201

Утас: 32-01-26, Факс: (976-11) 31-93-35,

Цахим шуудан: info@erc.gov.mn

Цахим хуудас: erc.gov.mn

2023.06.26 № 61890

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Санал ирүүлэх тухай**

Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Тусгай зөвшөөрлийн харилцааг зохицуулах аж ахуйн харилцааны дүрэм”-ийн төслийг шинэчлэн боловсруулж, тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс санал авахаар Хорооны *erc.gov.mn* веб сайтад 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдөр байршуулаад байна.

“Тусгай зөвшөөрлийн харилцааг зохицуулах аж ахуйн харилцааны дүрэм”-ийн төсөлтэй холбоотой тодруулгыг Тусгай зөвшөөрлийн газрын мэргэжилтэн Н.Жигжидсүрэн (холбоо барих утас 99077712)-тэй холбогдож авах боломжтой бөгөөд дүрмийн төсөлд тусгах саналаа хавсралт маягтын дагуу 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Хавсралт 1 хуудастай.

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН  
ГАЗРЫН ДАРГА



Х.НОМИНБИЛЭГ

Эрчим хүчний зохицуулах хорооны 2023 оны  
... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар  
албан бичгийн хавсралт



“Тусгай зөвшөөрлийн харилцааг зохицуулах аж ахуйн харилцааны дүрэм”-ийн  
төсөлд санал өгөх хуудас

д/д	Шинэчлэн боловсруулсан дүрмийн заалт	Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс өөрчлөлт оруулах болон нэмэх санал	Дүрмийн төсөлд өөрчлөлт оруулах, нэмэх саналын хууль, дүрэм журмын үндэслэл	Тайлбар
1	2	3	4	5
1				
2				
....				

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГАЗАР

## ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ АЖ АХУЙН ХАРИЛЦААНЫ ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ дүрмийн зорилго нь Эрчим хүчний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-ээс 12.12-т заасан тусгай зөвшөөрлийн (цаашид “тусгай зөвшөөрөл” гэх) нөхцөл, шаардлагыг тогтоох, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, нөхцөл шаардлагын хэрэгжилтэд хяналт тавих, бүртгэх, сонгон шалгаруулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Эрчим хүчний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн харилцааг Эрчим хүчний тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

1.3. Энэхүү дүрмийг Эрчим хүчний зохицуулах хороо (цаашид “ЭХЗХ” гэх), Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон хүсэлт гаргагч хуулийн этгээд дагаж мөрдөнө.

### Хоёр. Баримтлах зарчим

2.1. Эрчим хүчний салбарын үр ашгийг сайжруулах, өртөг зардлыг бууруулах, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, дэвшилтэт техник, технологи, ухаалаг систем нэвтрүүлэхийг дэмжинэ.

2.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн техникийн найдвартай байдал, үр ашиг, үйлчилгээний түвшнийг сайжруулах, тэдгээрийн чадавхыг бэхжүүлэхэд чиглэгдсэн байна.

2.3. Хэрэглэгчдэд хүрэх үйлчилгээний чанар нь стандартын шаардлага хангасан байна.

2.4. Ногоон эрчим хүч буюу сэргээгдэх эх үүсвэрийг дэмжих чиглэл баримтална.

2.5. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцааг харилцагч байгууллага, иргэдэд ил тод, нээлттэй, шуурхай болгох чиглэлд мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлнэ.

### Гурав. Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд тавигдах шаардлага, түүнийг бүртгэх

3.1. Тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь Эрчим хүчний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалтын дагуу үйл ажиллагааны төрөлтэй уялдуулан баримт бичгийг бүрдүүлж ирүүлэхдээ дараах баримтуудыг хавсаргаж ирүүлнэ. Үүнд :

3.1.1. Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг [www.license.erg.mn](http://www.license.erg.mn) цахим хуудсанд оруулсан маягтын дагуу гаргах;

3.1.2. Эрчим хүчний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан Төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөл, эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрлийн хувьд салбарын шинжлэх ухаан технологийн зөвлөлийн шийдвэр;

3.1.3. Хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрмийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, хуулийн этгээдийн бүтэц зохион байгуулалт, хүний нөөцийн талаарх дэлгэрэнгүй танилцуулга;

3.1.4. Үйл ажиллагаа явуулах барилга байгууламжийн талаарх мэдээлэл түүнтэй холбогдох гэрээ болон барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт;

3.1.5. Эрчим хүчний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.2, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.3-т заасан баримтыг ирүүлэхээс гадна нүүрсний уурхайн нөөц болон усны нөөцийн судалгаа, техникийн үзүүлэлтийн баталгаажуулсан хуулбарыг ирүүлнэ;

3.1.6. Эрчим хүчний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.3-т заасан баримтыг ирүүлэхээс гадна хүчдэлийн түвшин, давтамж, даралт, температур, сүлжээний нэвтрүүлэх чадварын хязгаар зэрэг үзүүлэлтийн баталгаажуулсан хуулбарыг ирүүлнэ;

3.1.7. Эрчим хүчний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.4, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.4-т заасан баримтыг ирүүлэхээс гадна Тоног төхөөрөмжүүдийн жагсаалт, төрөл марк, техникийн тодорхойлолтыг баталгаажуулсан хуулбарыг ирүүлнэ;

3.1.8. Эрчим хүчний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.5-д заасан баримтыг ирүүлэхээс гадна үйл ажиллагаа явуулах байршил, эзэмшлийн зааг ба эдгээрийг харуулсан зураг, схем, үйлдвэрлэх, дамжуулах, түгээх цахилгаан, дулааны дунд болон урт хугацааны хангамж хэрэглээний тэнцлийн судалгаа, мэдээллийг баталгаажуулсан хуулбарыг ирүүлнэ;

3.1.9. Эрчим хүчний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.7, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2-т заасан баримтыг ирүүлэхээс гадна Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг үндэслэж байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, зарцуулах хөрөнгийг тооцож эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан хуулбарыг ирүүлнэ;

3.1.10. Эрчим хүчний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.8-д заасан баримтыг ирүүлэхээс гадна эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрлийн хувьд төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн баталгаа, гаднын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх бол санхүүжилтийн болон зээлийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн гэрээ хэлцэл, баталгаат орчуулга, бусад тусгай зөвшөөрлийн хувьд тоног төхөөрөмж, шугам сүлжээг өмчлөлдөө шилжүүлэн авсан гэрээ хэлцэл, бүртгэсэн тайлан балансын баталгаажуулсан хуулбарыг ирүүлнэ;

3.1.11. Эрчим хүчний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.10-т заасан баримтыг ирүүлэхээс гадна Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрлийн хувьд төслийн гүйцэтгэгчийн ажлын туршлага, ажилтнуудын мэргэжил, боловсрол, тухайн чиглэлээр мэргэшсэн байдлын талаарх судалгаа, мэдээллийг ирүүлнэ.

3.2.Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд энэ дүрмийн 3.1-д зааснаас гадна дараах баримт бичгийг бүрдүүлсэн байна.

3.2.1.Эрчим хүчний үйл ажиллагаа эрхлэх зориулалтаар олгосон газар эзэмших эрхийн гэрчилгээ;

3.2.2.Нэгдсэн сүлжээнд холбогдон ажиллах үеийн горим тогтворжилтын тооцоо;

3.2.3.Эх үүсвэр, эх үүсгүүрийг нэгдсэн сүлжээнд холбох техникийн нөхцөл;

3.3.Тусгай зөвшөөрөл хүсэгч тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, холбогдох баримт бичгийг [www.license.erg.mn](http://www.license.erg.mn) цахим хуудсаар ирүүлэх бөгөөд ЭХЗХ-ны бичиг хэргийн ажилтан хүлээн авч бүртгэн, хүлээн авсан мэдэгдлийг өргөдөл ирүүлсэн цахим шууданд илгээнэ.

3.4. ЭХЗХ нь тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

3.5. Энэ дүрмийн 3.1, 3.2-д заасан өргөдөл, баримт бичгийн үнэн зөв байдлыг хуулийн этгээд бүрэн хариуцна.

3.6.ЭХЗХ-ны холбогдох мэргэжилтэн ирүүлсэн өргөдөл, баримт бичгийн хүрээнд газар дээр нь нягтлан шалгана.

3.7.ЭХЗХ нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийн төрөл тус бүрээр түүний нөхцөл, шаардлага, үндсэн тоноглолын үзүүлэлт, үйлчлэх хүрээг тогтооно.

3.8.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Эрчим хүчний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6-д заасан зохицуулалтын үйлчилгээний хөлс төлөх тухай гэрээг ЭХЗХ-той байгуулна.

### **Дөрөв. Сонгон шалгаруулалт**

4.1.Тухайн тодорхой нутаг дэвсгэрт хэд хэдэн хуулийн этгээд тусгай зөвшөөрөл шинээр авахаар, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйлчлэх хүрээ, эзэмшлийн заагт хамаарах хэрэглэгчийн эрчим хүчний түгээх, хангах үйл ажиллагааг хариуцан ажиллахаар хуулийн этгээдүүд хүсэлт гаргасан тохиолдолд Эрчим хүчний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.8 дахь заалтын дагуу сонгон шалгаруулах замаар шийдвэрлэнэ.

4.2.Сонгон шалгаруулалтыг ЭХЗХ-ны даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг явуулна.

4.3.Ажлын хэсэг сонгон шалгаруулалт хийхдээ өргөдөл гаргагч болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааг дараах үзүүлэлтүүдийг үндэслэн онооны системээр үнэлнэ.

4.3.1.ашиг, алдагдал (0-10 оноо)

4.3.2.өр, авлагын байдал (0-15 оноо)

4.3.3.техник, эдийн засгийн үзүүлэлтийг дээшлүүлэх талаар хийсэн болон хийхээр төлөвлөж буй ажил, түүний үр өгөөж (0-15 оноо)

4.3.4.тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны өртөг, зардлын өсөлт, бууралт (0-15 оноо)

4.3.5.тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай техник тоног төхөөрөмж, боловсон хүчин (0-15 оноо)

4.3.6.тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны үйл ажиллагаа эрхлэх дадлага, туршлага (0-10 оноо)

4.3.7.Эрчим хүчний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалтад нийцсэн байдал, дулаан дамжуулах тухайн салаа шугамын холболтын схем, хэрэглэгчийн дулааны ачааллын эзлэх (0-10)

4.3.8.Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтийн дүнг харгалзан үзнэ. (0-10)

4.4.Ажлын хэсэг нь энэ дүрмийн 4.3.1-4.3.8-д заасан үзүүлэлттэй холбоотой баримт, бичгийг өргөдөл гаргагчаас шаардах эрхтэй.

4.5.Ажлын хэсэг нь өргөдөл гаргагчийн үйл ажиллагааг үзүүлэлт бүрээр дүгнэн нийлбэр оноог гаргаж, хамгийн өндөр оноо авсан нэг хуулийн этгээдийг сонгон шалгаруулалтад шалгарсан гэж үзэн холбогдох дүгнэлтээ ЭХЗХ-ны хуралд танилцуулж шийдвэрлүүлнэ.

### **Тав. Тусгай зөвшөөрлийн нөхцөл**

5.1.Эрчим хүчний тухай хуулийн 12.1 дэх заалтын дагуу үйл ажиллагаа эрхэлж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч болон шинээр хүсэгч хуулийн этгээд тусгай зөвшөөрлийн төрлөөс хамааран дараахь нөхцөлүүдийг хангасан байна.

5.1.1.тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулах боломжтой, санхүүгийн чадавхтай,

5.1.2.үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай тусгай зориулалтын технологийн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг бүрдүүлсэн,

5.1.3.мэргэжлийн түвшинд бэлтгэгдсэн, тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг аюулгүй, эдийн засгийн үр ашигтай явуулах дадлага, туршлага бүхий хүний нөөцтэй,

5.1.4. эрчим хүчний хэмнэлтийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжтой,

5.1.5.үйлдвэрлэсэн, дамжуулсан, түгээсэн, хангасан эрчим хүчийг хэмжих баталгаажсан тоолуур, хэмжих хэрэгсэлтэй байх,

5.1.6.техникийн алдагдал, горим тооцоо, борлуулалт, хэрэглэгчийн үйлчилгээний программ хангамжууд, тайлагналын системтэй байх,

5.1.7.үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах багаж хэрэгсэл, машин механизмтай байх,

5.1.8.гарч болзошгүй аваар, ослоос урьдчилан сэргийлэх төлөвлөгөө, аюулгүйн нөөцийг бүрдүүлсэн байх,

5.1.9.байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөртэй байх, тэдгээрийг хугацаанд нь хэрэгжүүлэх,

5.1.10. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангасан, эрүүл, аюулгүй ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлсэн байх,

5.1.11.цахилгаан түгээх, цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл олгоход цахилгаан эрчим хүчний түгээлт жилд 10 сая кВт.ц-аас багагүй, цахилгаан түгээх сүлжээ үүсгэж өмчлөлдөө бүртгэсэн,

5.1.12.дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл олгоход дулааны эрчим хүчний хэрэглэгчдийн тооцоот ачаалал 20 Гкал/ц-аас багагүй, дулаан түгээх сүлжээ үүсгэж өмчлөлдөө бүртгэж авсан,

### **Зургаа. Тусгай зөвшөөрлийн шаардлага, түүний биелэлтийг тайлагнах, дүгнэх**

6.1.Тусгай зөвшөөрлийн шаардлагыг төрөл тус бүрээр энэ дүрмийн 6.3-т дагуу тогтооно.

6.2.Эрчим хүчний тухай хуулийн 12.1.1-12.1.10, 12.1.12 дахь заалтад заасан тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хүрээнд мөрдөж ажиллах шаардлага, түүний харгалзах оноог хяналт шалгалтын тайлан, аудитын зөвлөмж, үйл ажиллагааны доголдож байгаа үзүүлэлтүүдээс хамааруулан жил бүр тогтооно.

6.3.Эрчим хүчний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-ээс 12.12-т заасан үйл ажиллагаа эрхэлж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах шаардлагыг хангасан байна.

6.3.1.Цахилгаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн шаардлага:

6.3.1.1.Цахилгаан үйлдвэрлэлийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж, осол, аваар, сааталгүй ажиллах,

6.3.1.2.Диспетчерийн зохицуулалтыг мөрдөж стандартын шаардлага хангасан цахилгаан үйлдвэрлэх,

6.3.1.3.Цахилгаан, дулаан үйлдвэрлэх үйл ажиллагааг техник, технологийн шаардлага, хамгийн бага өртгийн шалгуурт нийцүүлэн найдвартай, үр ашигтай явуулах,

6.3.1.4.Цахилгаан үйлдвэрлэх тоноглолын засвар үйлчилгээ, өргөтгөл шинэчлэлийг эрсдэлийн үнэлгээг үндэслэн эрэмбэлэн төлөвлөж холбогдох дүрэм, журам, заавар, норм нормативын дагуу чанартай, үр дүнтэй бүрэн хийж гүйцэтгэх, үр ашиг, өгөөжийг тооцож тайлагнах,

6.3.1.5.Эрчим хүчний эх үүсгүүрээс байгаль орчинд хаях бохирдлыг холбогдох стандартаар тогтоосон хэмжээнд байлгах,

6.3.1.6.Үйлдвэрлэлийн барилга болон далангийн ашиглалт, аюулгүй байдал, усан сангийн ашиглалт, хамгаалалт, усны түвшин, голын урсац зэргийг багтаасан хяналт-шинжилгээний төлөвлөгөө, хөтөлбөр гаргаж, холбогдох байгууллагаар батлуулах,

6.3.1.7.Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны санхүүгийн тайлан бүртгэлийг бусад үйл ажиллагааны тайлан бүртгэлээс тусад нь бүртгэж, тайлагнах,

6.3.1.8.Батлагдсан тарифт тусгагдсан зардлыг үр ашигтай зарцуулж ажиллах,

6.3.1.9.Авлага болон богино хугацаат өр төлбөрийг өсгөхгүй байх, санхүүгийн зохистой харьцааг хангаж ажиллах,

6.3.1.10.Хяналт шалгалт, аудитын зөвлөмжийн дагуу тухайн үеийн холбогдох арга хэмжээг авч ажиллах;

### 6.3.2. Дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн шаардлага:

6.3.2.1. Дулаан үйлдвэрлэлийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж, осол, аваар сааталгүй ажиллах,

6.3.2.2. Үйлдвэрлэх дулааны эрчим хүчний горим, төлөвлөлтийг оновчтой төлөвлөж оны эхэнд баталсан төлөвлөгөөг мөрдөх, стандартын шаардлага хангасан дулааны эрчим хүч үйлдвэрлэх,

6.3.2.3. Дулаан үйлдвэрлэх үйл ажиллагааг техник, технологийн шаардлага, хамгийн бага өртгийн шалгуурт нийцүүлэн найдвартай үр ашигтай явуулах,

6.3.2.4. Дулаан үйлдвэрлэх тоноглолын засвар үйлчилгээ, өргөтгөл шинэчлэлийг эрсдэлийн үнэлгээг үндэслэн эрэмбэлэн төлөвлөж холбогдох дүрэм, журам, заавар, норм нормативын дагуу чанартай, үр дүнтэй бүрэн хийж гүйцэтгэх, үр ашиг, өгөөжийг тооцож тайлагнах,

6.3.2.5. Эрчим хүчний эх үүсгүүрээс байгаль орчинд хаях бохирдлыг холбогдох стандартаар тогтоосон хэмжээнд байлгах,

6.3.2.6. Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны санхүүгийн тайлан бүртгэлийг бусад үйл ажиллагааны тайлан бүртгэлээс тусад нь бүртгэж, тайлагнах,

6.3.2.7. Батлагдсан тарифт тусгагдсан зардлыг үр ашигтай зарцуулж ажиллах,

6.3.2.8. Авлага болон богино хугацаат өр төлбөрийг өсгөхгүй байх, санхүүгийн зохистой харьцааг хангаж ажиллах,

6.3.2.9. Хяналт шалгалт, аудитын зөвлөмжийн дагуу тухайн үеийн холбогдох арга хэмжээг авч ажиллах,

### 6.3.3. Цахилгаан дамжуулах тусгай зөвшөөрлийн шаардлага:

6.3.3.1. Цахилгаан дамжуулах сүлжээний аюулгүй, найдвартай ажиллагааг хангаж, осол, аваар, сааталгүй ажиллах,

6.3.3.2. Цахилгаан дамжуулах үйл ажиллагааг техник технологийн шаардлагад нийцүүлэн тасралтгүй, үр ашигтай явуулах,

6.3.3.3. Цахилгаан дамжуулах сүлжээний ашиглалт засвар үйлчилгээ, өргөтгөл шинэчлэлийг эрсдэлийн үнэлгээг үндэслэн эрэмбэлэн төлөвлөж холбогдох дүрэм, журам, заавар, норм нормативын дагуу чанартай, үр дүнтэй бүрэн хийж түүний хэвийн найдвартай ажиллагааг хангах гүйцэтгэх, үр ашиг, өгөөжийг тооцож тайлагнах,

6.3.3.4. Цахилгаан дамжуулах сүлжээнд холбогдсон түгээх сүлжээ болон хэрэглэгчдийг Нэгдсэн сүлжээний дүрэмд заасан стандартын шаардлага хангасан цахилгаан эрчим хүчээр хангах,

6.3.3.5. Цахилгаан дамжуулах сүлжээний техникийн алдагдлыг дэд станц, шугам бүрээр, батлагдсан аргачлал болон тооцооны программ хангамжаар улирал, жилээр тооцоолох, алдагдлыг бууруулах,

6.3.3.6. Цахилгаан дамжуулах сүлжээг өргөтгөх, хэтийн хөгжлийн төлөвлөгөөтэй байх, шаардлагатай мэдээллээр хангах; шинэчлэх хэтийн хөгжлийн төлөвлөгөөнд дамжуулах сүлжээний найдвартай ажиллагааны түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн шинэ дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх, хуримтлуурын байгууламж, бага оврын СЭХ-ний эх үүсгүүрээс дотоод хэрэгцээг хангах зэрэг шийдлийг тусгаж, хэрэгжүүлэх,



6.3.3.7.Цахилгаан дамжуулах шугамын хамгаалалтын зурвасын хэвийн байдлыг хангахад тухайн орон нутгийн засаг захиргааны байгууллагуудтай хамтран хангах,

6.3.3.8.Батлагдсан тарифт тусгагдсан зардлыг үр ашигтай зарцуулж ажиллах,

6.3.3.9.Авлага болон богино хугацаат өр төлбөрийг өсгөхгүй байх, санхүүгийн зохистой харьцааг хангаж ажиллах,

6.3.3.10.Хяналт шалгалт, аудитын зөвлөмжийн дагуу тухайн үеийн холбогдох арга хэмжээг авч ажиллах,

6.3.4.Дулаан дамжуулах тусгай зөвшөөрлийн шаардлага:

6.3.4.1.Дулаан дамжуулах сүлжээний аюулгүй, найдвартай ажиллагааг хангаж, осол, аваар, сааталгүй ажиллах,

6.3.4.2.Худалдан авах дулааны эрчим хүчний горим, төлөвлөлтийг оновчтой төлөвлөж оны эхэнд баталсан төлөвлөгөөг холбогдох дүрэмд заасан хэмжээнээс хэтрүүлэхгүй ажиллах,

6.3.4.3.Дулаан дамжуулах сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээ, өргөтгөл шинэчлэлийг эрсдэлийн үнэлгээг үндэслэн эрэмбэлэн төлөвлөж холбогдох дүрэм, журам, заавар, норм нормативын дагуу чанартай, үр дүнтэй хийж түүний хэвийн найдвартай ажиллагааг хангах, бүрэн хийж гүйцэтгэх, үр ашиг, өгөөжийг тооцож тайлагнах,

6.3.4.4.Дулаан дамжуулах үйл ажиллагааг техник технологийн шаардлагад нийцүүлэн тасралтгүй, үр ашигтай явуулах,

6.3.4.5.Дулаан хэрэглэх дүрэм, Дулаан дамжуулах сүлжээний холболтын журмын дагуу дулаан дамжуулах сүлжээг төрийн өмчид шилжүүлэн авах арга хэмжээг зохион байгуулах,

6.3.4.6.Дулаан дамжуулах сүлжээнд холбогдсон түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон хэрэглэгчдийг стандартын шаардлага хангасан дулаанаар хангах, шинээр холбогдсон барилга байгууламжуудыг тухайн салаа шугамыг хариуцан ажиллаж буй дулаан түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэх,

6.3.4.7.Дулаан дамжуулах сүлжээг өргөтгөх, шинэчлэх хэтийн хөгжлийн төлөвлөгөөнд байх, шаардлагатай мэдээллээр хангах дамжуулах сүлжээний найдвартай ажиллагааны түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн шинэ дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх асуудлыг тусгаж, хэрэгжүүлэх,

6.3.4.8.Дулаан дамжуулах шугамын хамгаалалтын зурвасын хэвийн байдлыг хангахад тухайн орон нутгийн засаг захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах,

6.3.4.9.Батлагдсан тарифт тусгагдсан зардлыг үр ашигтай зарцуулж ажиллах,

6.3.4.10.Авлага болон богино хугацаат өр төлбөрийг өсгөхгүй байх, санхүүгийн зохистой харьцааг хангаж ажиллах,

6.3.4.11.Худалдан авсан эрчим хүчний төлбөрийг бүрэн төвлөрүүлсэн байх;

6.3.4.12.Хяналт шалгалт, аудитын зөвлөмжийн дагуу тухайн үеийн холбогдох арга хэмжээг авч ажиллах,

6.3.5.Диспетчерийн зохицуулалт хийх тусгай зөвшөөрлийн шаардлага:

6.3.5.1.Эрчим хүчний үйлдвэрлэл хангамжийг стандартын шаардлага болон хамгийн бага өртгийн шалгуурт нийцүүлэн үр ашигтай диспетчерийн зохицуулалт хийж хэрэгжүүлсэн талаарх тайлан, дүгнэлтийг сар бүрийн 10-ны дотор ЭХЗХ-нд ирүүлэх,

6.3.5.2.Цахилгааны нэг худалдан авагчтай загвар, Спот зах зээл, Өрсөлдөөнт зах зээлийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, эдийн засгийн үр ашигтай горимыг бий болгоход хяналт тавьж ажиллах, холбогдох дүрэм журмыг боловсронгуй болгох талаар санал боловсруулж ЭХЗХ-оор батлуулж мөрдөж ажиллах,

6.3.5.3.Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, хэрэглээг тэнцвэржүүлж, хангамж, хэрэглээний дунд болон урт хугацааны төлөвлөлтийг хийх;

6.3.5.4.Нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд эрчим хүчний хангамж хэрэглээний тасралтгүй найдвартай ажиллагааг хангах үүднээс цахилгаан, дулаан болон импорт, экспортын хэмжээг жилийн  $\pm 2$  хувиас илүүгүй өөрчлөлттэйгөөр төлөвлөх,

6.3.5.5.Нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамжийн системийг хамарсан аваар, саатлыг бүрэн бүртгэж хяналт тавих, тэдгээрийн шалтгаан нөхцөлд “Нэгдсэн сүлжээний дүрэм”-ийн дагуу оновчтой дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх,

6.3.5.6.Шинээр нэвтэрч буй техник технологийн шаардлагыг тусган Нэгдсэн сүлжээний дүрмийг олон улсын жишигт нийцсэн байдлаар шинэчлэн боловсруулж, мөрдөж ажиллах;

6.3.5.7.Эрчим хүчний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4 дэх заалтын дагуу Нэгдсэн сүлжээ, Төвлөрсөн дулаан хангамжийн нэгдмэл үйл ажиллагааг хангах горим тогтоож хянах, диспетчерийн зохицуулалтыг бүрэн хэрэгжүүлэх,

6.3.5.8.Нэгдсэн сүлжээний дүрмийн 7.1-д заасны дагуу цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний техникийн алдагдлын норм, нормчлолыг тогтоох саналыг боловсруулан Төрийн захиргааны төв байгууллагаар батлуулж, мөрдөж ажиллах,

6.3.5.9.Байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүссэн тохиолдолд цахилгаан, дулааны хангамжийг таслах, хязгаарлах, сэргээх төлөвлөгөөг авч хэрэгжүүлэх,

6.3.5.10.Батлагдсан тарифт тусгагдсан зардлыг үр ашигтай зарцуулж ажиллах,

6.3.5.11.Авлага болон богино хугацаат өр төлбөрийг өсгөхгүй байх, санхүүгийн зохистой харьцааг хангаж ажиллах,

6.3.5.12.Худалдан авсан эрчим хүчний төлбөрийг бүрэн төвлөрүүлсэн байх;

6.3.5.13.Хяналт шалгалт, аудитын зөвлөмжийн дагуу тухайн үеийн холбогдох арга хэмжээг авч ажиллах,

6.3.6.Цахилгаан түгээх тусгай зөвшөөрлийн шаардлага:

6.3.6.1.Цахилгаан түгээх сүлжээний аюулгүй ажиллагааг хангах, осол, аваар, сааталгүй ажиллах,

6.3.6.2.Цахилгаан түгээх сүлжээний алдагдлыг дэд станц, шугам бүрээр, батлагдсан аргачлал болон тооцооны программ хангамжаар улирал, жилээр тооцоолох, техникийн болон арилжааны алдагдлыг бууруулах,

6.3.6.3.Цахилгаан түгээх сүлжээний үйл ажиллагааг техник технологийн шаардлагад нийцүүлэн тасралтгүй, үр ашигтай явуулах,

6.3.6.4.Цахилгаан эрчим хүчний түгээлт жилд 10 сая кВт.ц-аас багагүй, цахилгаан түгээх сүлжээ үүсгэж өмчлөлдөө бүртгэсэн байх,

6.3.6.5.Цахилгаан түгээх сүлжээний ашиглалт засвар үйлчилгээ, өргөтгөл шинэчлэлийг эрсдэлийн үнэлгээг үндэслэн эрэмбэлэн төлөвлөж холбогдох дүрэм, журам, заавар, норм нормативын дагуу чанартай, үр дүнтэй хийж түүний хэвийн найдвартай ажиллагааг хангах,

бүрэн хийж гүйцэтгэх, үр ашиг, өгөөжийг тооцож тайлагнах,

6.3.6.6.Цахилгаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдийг Нэгдсэн сүлжээний дүрэмд заасан стандартын шаардлага хангасан цахилгаан эрчим хүчээр хангах,

6.3.6.7.Цахилгаан түгээх сүлжээг өргөтгөх, шинэчлэх хэтийн хөгжлийн төлөвлөгөөнд байх, шаардлагатай мэдээллээр хангах түгээх сүлжээний найдвартай ажиллагааны түвшинг чиглэсэн шинэ дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх, хуримтлуурын байгууламж, бага оврын СЭХ-ний эх үүсгүүрээс дотоод хэрэгцээг хангах зэрэг шийдлийг тусгаж, хэрэгжүүлэх,

6.3.6.8.Хэрэглэгчийн бага оврын тархмал эх үүсгүүрээс түгээх сүлжээнд нийлүүлэх цахилгаан эрчим хүчний хэмжээ, чадлын дээд хязгаарыг жил бүр тооцож, ЭХЗХ-нд тайлагнах,

6.3.6.9.Цахилгаан түгээх сүлжээний хамгаалалтын зурвасын хэвийн байдлыг хангах зорилгоор иргэд, хуулийн этгээдэд шаардлага, хяналт тавих,

6.3.6.10.Батлагдсан тарифт тусгагдсан зардлыг үр ашигтай зарцуулж ажиллах;

6.3.6.11.Авлага болон богино хугацаат өр төлбөрийг өсгөхгүй байх, санхүүгийн зохистой харьцааг хангаж ажиллах,

6.3.6.12.Худалдан авсан эрчим хүчний төлбөрийг бүрэн төвлөрүүлсэн байх,

6.3.6.13.Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны санхүүгийн тайлан бүртгэлийг бусад үйл ажиллагааны тайлан бүртгэлээс тусад нь бүртгэж, тайлагнах,

6.3.6.14.Хяналт шалгалт, аудитын зөвлөмжийн дагуу тухайн үеийн холбогдох арга хэмжээг авч ажиллах,

6.3.7.Дулаан түгээх тусгай зөвшөөрлийн шаардлага:

6.3.7.1.Дулаан түгээх сүлжээний аюулгүй, найдвартай ажиллагааг хангаж, осол, аваар, сааталгүй ажиллах, гарсан аваар, саатал, тасралтыг холбогдох дүрэм, журмын хүрээнд Диспетчерийн үндэсний төвд шуурхай мэдээлэх,

6.3.7.2.Худалдан авах дулааны эрчим хүчний хэмжээг оновчтой төлөвлөж, жилийн  $\pm 2$  хувиас хэтрүүлэхгүй байх, стандартын шаардлагад нийцсэн дулаан түгээх,

6.3.7.3.Дулаан түгээх сүлжээний засвар үйлчилгээ, өргөтгөл шинэчлэлийг эрсдэлийн үнэлгээг үндэслэн эрэмбэлэн төлөвлөж холбогдох дүрэм, журам, заавар, норм нормативын дагуу чанартай, үр дүнтэй бүрэн хийж гүйцэтгэх, үр ашиг, өгөөжийг тооцож тайлагнах,

6.3.7.4.Дулаан түгээх сүлжээний үйл ажиллагааг техник технологийн шаардлагад нийцүүлэн тасралтгүй, үр ашигтай явуулах,

6.3.7.5. Дулаан хэрэглэх дүрэм, Дулаан дамжуулах сүлжээний холболтын журмын дагуу дулаан дамжуулах сүлжээг төрийн өмчид шилжүүлэх,

6.3.7.6. Эрчим хүчний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалтад нийцээгүй барилга, байгууламжуудын дулаан түгээх үйл ажиллагааг тухайн дулаан дамжуулах салаа шугамын хамгийн их ачаалалтай хэрэглэгчдийг хариуцан ажиллаж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэх, түүнээс шилжүүлэн авах, 200 мм хүртэл голчтой дулаан дамжуулах сүлжээг дангаар хариуцан ажиллах,

6.3.7.7. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хариуцан ажиллаж буй дулаан дамжуулах, түгээх сүлжээнээс холбогдсон хэрэглэгч (барилга байгууламж)-ийн дулаан түгээх сүлжээ, үйл ажиллагааг шилжүүлэн авахгүй байх,

6.3.7.8. Дулааны эрчим хүчний хэрэглэгчдийн тооцоот ачаалал 20 Гкал/ц-аас багагүй, дулаан түгээх сүлжээ үүсгэж өмчлөлдөө бүртгэж авсан байх,

6.3.7.9. Дулаан түгээх сүлжээний хамгаалалтын зурвасын хэвийн байдлыг хангах зорилгоор иргэд, хуулийн этгээдэд шаардлага, хяналт тавих,

6.3.7.10. Гадна агаарын хэмээс хамааруулсан дулааны эрчим хүчний хангамж, хэрэглээний тэнцлийг сар бүрээр тооцож гаргах,

6.3.7.11. Батлагдсан тарифт тусгагдсан зардлыг үр ашигтай зарцуулж ажиллах,

6.3.7.12. Авлага болон богино хугацаат өр төлбөрийг өсгөхгүй байх, санхүүгийн зохистой харьцааг хангаж ажиллах,

6.3.7.13. Худалдан авсан эрчим хүчний төлбөрийг бүрэн төвлөрүүлсэн байх;

6.3.7.14. Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны санхүүгийн тайлан бүртгэлийг бусад үйл ажиллагааны тайлан бүртгэлээс тусад нь бүртгэж, тайлагнах,

6.3.7.15. Хяналт шалгалт, аудитын зөвлөмжийн дагуу тухайн үеийн холбогдох арга хэмжээг авч ажиллах,

6.3.8. Цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийн шаардлага:

6.3.8.1. ЭХЗХ-ноос баталсан зах зээлийн загвар, дүрэм, журмын дагуу бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс цахилгаан худалдан авах,

6.3.8.2. Цахилгаан эрчим хүчний хэрэглээний захиалгыг оны эхэнд баталсан төлөвлөгөөнөөс  $\pm 2$  хувиас хэтрүүлэхгүй байх, худалдан авсан цахилгааны төлбөрийг бүрэн төвлөрүүлсэн байх,

6.3.8.3. Хэрэглэгчийг стандартын шаардлага хангасан цахилгаан эрчим хүчээр хангаж, цахилгаан тасалдлын индексийг өмнөх оноос бууруулах,

6.3.8.4. Хэрэглэгчдэд худалдсан цахилгааны орлогыг цахилгаан нийлүүлэгчтэй байгуулсан цахилгаан худалдах, худалдан авах гэрээнд заасан харилцах дансанд төвлөрүүлэх, худалдан авсан цахилгааны төлбөрийг уг данснаас бусад иргэн, хуулийн этгээдээр дамжуулахгүйгээр цахилгаан нийлүүлэгчид шууд төлөх,

6.3.8.5. Хэрэглэгчдэд цахилгаан худалдахад урьдчилсан төлбөрт болон ухаалаг тоолуурын системийг нэвтрүүлэх,

6.3.8.6. Бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй байгуулсан цахилгаан худалдах, худалдан авах гэрээг Диспетчерийн үндэсний төвд бүртгүүлж, гэрээний биелэлтийг сар бүр тэдгээртэй хамтран дүгнэх, худалдан авсан,

худалдсан цахилгааны тэнцлийг хийх тоолуур хэмжүүрийн баталгаажуулалт, бүрэн бүтэн байдалд хяналт тавих,

6.3.8.7.Хэрэглэгчийн хууль ёсны эрх ашгийг хангаж ажиллах, хэрэглэгчийн санал, гомдлыг хүлээн авах, бүрэн шийдвэрлэх,

6.3.8.8.Хэрэглэгчдийг стандартын шаардлага хангасан цахилгаан эрчим хүчээр хангаж, цахилгаан тасалдлын индексийг өмнөх оноос бууруулах;

6.3.8.9.Батлагдсан тарифт тусгагдсан зардлыг үр ашигтай зарцуулж ажиллах,

6.3.8.10.Авлага болон богино хугацаат өр төлбөрийг өсгөхгүй байх, санхүүгийн зохистой харьцааг хангаж ажиллах,

6.3.8.11.Худалдан авсан эрчим хүчний төлбөрийг бүрэн төвлөрүүлсэн байх;

6.3.8.12.Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны санхүүгийн тайлан бүртгэлийг бусад үйл ажиллагааны тайлан бүртгэлээс тусад нь бүртгэж, тайлагнах,

6.3.8.13.Хяналт шалгалт, аудитын зөвлөмжийн дагуу тухайн үеийн холбогдох арга хэмжээг авч ажиллах,

6.3.9.Дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийн шаардлага:

6.3.9.1.Дулаан түгээх сүлжээний гидравлик тооцоог боловсруулж хангагчтай зөвшилцөх, стандартын шаардлагад нийцсэн дулаанаар хангах;

6.3.9.2.Дулааны эрчим хүчний хэрэглээний захиалгыг оны эхэнд баталсан төлөвлөгөөнөөс  $\pm 2$  хувиас хэтрүүлэхгүй байх,

6.3.9.3.Эрчим хүчний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалтад нийцээгүй барилга, байгууламжуудын дулаанаар зохицуулалттай хангах үйл ажиллагааг тухайн дулаан дамжуулах салаа шугамын хамгийн их ачаалалтай хэрэглэгчдийг хариуцан ажиллаж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэх, түүнээс шилжүүлэн авах,

6.3.9.4.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хариуцан ажиллаж буй дулаан дамжуулах, түгээх сүлжээнээс холбогдсон хэрэглэгч (барилга байгууламж)-ийн дулаанаар зохицуулалттай хангах үйл ажиллагааг шилжүүлэн авахгүй байх,

6.3.9.5.Дулаанаар зохицуулалттай хангах үйл ажиллагаандаа бусад иргэд, хуулийн этгээдийн эзэмшлийн шугам, тоног төхөөрөмжийг ашиглаж байгаа бол үйлчилгээний төлбөрийг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд заасны дагуу тооцож төлөх,

6.3.9.6.Хэрэглэгчийн хууль ёсны эрх ашгийг хангаж ажиллах, хэрэглэгчийн санал, гомдлыг хүлээн авах, бүрэн шийдвэрлэх,

6.3.9.7.Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны санхүүгийн тайлан бүртгэлийг бусад үйл ажиллагааны тайлан бүртгэлээс тусад нь бүртгэж, тайлагнах,

6.3.9.8.Бусад тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчтэй байгуулсан дулаан худалдах, худалдан авах гэрээний биелэлтийг улирал бүр тэдгээртэй хамтран дүгнэх, худалдан авсан, худалдсан дулааны тэнцлийг хийх тоолуур хэмжүүрийн баталгаажуулалт, бүрэн бүтэн байдалд хяналт тавих,

6.3.9.9.Хэрэглэгчдэд худалдсан дулааны төлбөрийг тэдгээртэй байгуулсан гэрээнд заасан хугацаанд бүрэн цуглуулж авах, худалдан авсан дулааны төлбөрийг дулаан худалдах, худалдан авах гэрээнд заасан хугацаанд бүрэн

- төлөх; төвлөрүүлэх, “Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн аж ахуйн харилцааны дүрэм”-д заасан “Дулааны нэг худалдан авагч”-тай мөрдөж ажиллах,
- 6.3.9.10. Дулаанаар хангах үйл ажиллагааг дулааны тооцооны тоолуураар бүрэн тоолууржуулах,
- 6.3.9.11. Тарифыг тооцох борлуулалтын орлого болон өртөг зардал тооцоход шаардлагатай бусад мэдээ мэдээлэл, холбогдох тайлан, тооцоо судалгааг үнэн зөв гаргаж тайлагнах, түүнээс үүссэн аливаа эрсдэлийг бүрэн хариуцах,
- 6.3.9.12. Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомж, дулааны эрчим хүч худалдагч, хэрэглэгч талуудын эрх, үүрэг, хоорондын гэрээний талаар болон эрчим хүчийг үр ашигтай, зүй зохистой хэрэглэх талаар олон нийтэд тогтмол мэдээлэх, сурталчлах,
- 6.3.9.13. Батлагдсан тарифт тусгагдсан зардлыг үр ашигтай зарцуулж ажиллах,
- 6.3.9.14. Авлага болон богино хугацаат өр төлбөрийг өсгөхгүй байх, санхүүгийн зохистой харьцааг хангаж ажиллах,
- 6.3.9.15. Худалдан авсан эрчим хүчний төлбөрийг бүрэн төвлөрүүлсэн байх;
- 6.3.9.16. Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны санхүүгийн тайлан бүртгэлийг бусад үйл ажиллагааны тайлан бүртгэлээс тусад нь бүртгэж, тайлагнах,
- 6.3.9.17. Хяналт шалгалт, аудитын зөвлөмжийн дагуу тухайн үеийн холбогдох арга хэмжээг авч ажиллах,
- 6.3.10. Эрчим хүчээр зохицуулалтгүй хангах тусгай зөвшөөрлийн шаардлага
- 6.3.10.1. ЭХЗХ-оос тогтоосон Эрчим хүчээр зохицуулалтгүй хангагдах хэрэглэгчийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэх;
- 6.3.10.2. Хэрэглэгчид худалдах эрчим хүчний гэрээний үнийг тодорхойлж тус гэрээг ЭХЗХ-нд бүртгүүлэх;
- 6.3.10.3. Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд ЭХЗХ-ноос тогтоосон хэрэглэгчдийг эрчим хүчээр найдвартай хангахад хүрэлцэх хэмжээний чадал, эрчим хүч авах талаар үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй тохиролцох;
- 6.3.10.4. Худалдан авсан эрчим хүчний төлбөрийг иргэн, хуулийн этгээдээр дамжуулахгүйгээр үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид шууд төлөх;
- 6.3.10.5. Хэрэглэгчийн хууль ёсны эрх ашгийг хангаж ажиллах, хэрэглэгчийн санал, гомдлыг хүлээн авах, бүрэн шийдвэрлэх;
- 6.3.10.6. Хяналт шалгалт, аудитын зөвлөмжийн дагуу тухайн үеийн холбогдох арга хэмжээг авч ажиллах;
- 6.3.11. Цахилгаан импортлох, экспортлох тусгай зөвшөөрлийн шаардлага
- 6.3.11.1. Цахилгаан импортлох, экспортлох сүлжээний аюулгүй ажиллагааг хангах, осол, аваар, сааталгүй ажиллах,
- 6.3.11.2. Цахилгаан импортлох, экспортлох шугам сүлжээний техникийн алдагдлыг дэд станц, шугам бүрээр батлагдсан аргачлал, тооцооны программ хангамж ашиглан улирал, жилээр тооцоолох, алдагдлыг нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээг тогтмол авах, алдагдлыг бууруулах тооцоо, судалгаа төлөвлөгөөтэй ажилласнаар импортын алдагдлыг бууруулах,

6.3.11.3.Импорт, экспортын цахилгаан эрчим хүчний төлөвлөлтөд харьцуулан дүн, шинжилгээ хийж, дүгнэлт гарган ажиллах,

6.3.11.4.Цахилгаан импортлох, экспортлох, шугам сүлжээг өргөтгөх хэтийн хөгжлийн төлөвлөгөөтэй байх, шаардлагатай мэдээллээр хангах,

6.3.11.5.Цахилгаан импортлох, экспортлох шугамын хамгаалалтын зурвасын баталгаажуулалт хийлгэж, түүний хэвийн байдлыг хангуулах чиглэлээр тухайн орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хамтран хангах нягт хамтарч ажиллах,

6.3.11.6.Импортлосон, экспортлосон цахилгаан эрчим хүчний төлбөрийг гэрээний дагуу сар бүр бүрэн төвлөрүүлэх,

6.3.11.7.Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ЭХЗХ, Диспетчерийн үндэсний төвөөс цахилгаан импортлох нөхцөл, болзлын талаар Эрх бүхий байгууллагаас өгсөн удирдамж чиглэлийн дагуу цахилгаан импортлох, экспортлох гэрээ байгуулах, түүний хуулбар болон гэрээнд орсон өөрчлөлтийг тухай бүр ирүүлэх,

6.3.11.8.Хяналт шалгалт, аудитын зөвлөмжийн дагуу тухайн үеийн холбогдох арга хэмжээг авч ажиллах,

6.3.12.Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрлийн шаардлага:

6.3.12.1.Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ байгуулсан байх;

6.3.12.2.Тусгай зөвшөөрөл олгосон өдрөөс хойш 24 сарын дотор барилга байгууламжийг заасан хугацаанд барьж ашиглалтад оруулахад шаардагдах хөрөнгийг санхүүжүүлэх талаар хөрөнгө оруулагч талуудтай гэрээ байгуулсан байх;

6.3.12.3.“Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм” болон холбогдох бусад дүрэм, журмын дагуу барилга байгууламжийн зураг төслийг эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлж, баталгаажуулсан хувийг ирүүлэх;

6.3.12.4.“Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн дагуу барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийлгэсэн хувийг ирүүлэх;

6.3.12.5.Барилга байгууламжийн барилга угсралтын ажлыг хөрөнгө оруулагчтай гэрээ байгуулагдсанаас хойш холбогдох хууль журмын хүрээнд 12 сарын дотор эхлүүлсэн байх;

6.3.12.6.Эрчим хүчний барилга байгууламжийг тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд барьж байгуулан, ашиглалтад оруулах;

6.3.12.7.Хяналт шалгалт, аудитын зөвлөмжийн дагуу тухайн үеийн холбогдох арга хэмжээг авч ажиллах;

6.4.Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараа жилийн 1 дүгээр сарын 10-ны дотор, бусад төрлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьд дараа жилийн 2 дугаар сарын 20-ны дотор тусгай зөвшөөрлийн шаардлагын биелэлтийг цахим системээр тайлагнах бөгөөд мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцна.

6.5.Тусгай зөвшөөрлийн шаардлагын биелэлтийг энэ дүрмийн 6.2-д заасан хугацаанд тайлагнаагүй тохиолдолд “Хангалтгүй” үнэлгээгээр дүгнэнэ.

6.6.Тусгай зөвшөөрлийн шаардлагын биелэлтийн оноонд харгалзан дараах үнэлгээгээр дүгнэнэ.

Биелэлтийн оноо (%)	Үнэлгээ
90-ээс 100 хүртэл	Хангалттай сайн
75-аас 90 хүртэл	Сайн
60-аас 75 хүртэл	Дунд
60 хүртэл	Хангалтгүй

6.7.ЭХЗХ нь технологийн болон үйл ажиллагааны онцлог, үйлчлэх хүрээ зэргээс хамааруулан тусгай зөвшөөрлүүдийн шаардлагыг нэгтгэн тогтоож энэ дүрмийн хавсралтад заасан аргачлалын дагуу дүгнэнэ.

6.8.Өөрийн хэрэгцээг хангах зориулалттай цахилгаан, дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дуусгавар болоход тогтоосон шаардлагад харгалзах нийт онооны арифметик дунджаар биелэлтийг үнэлнэ.

6.9.Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрлийн шаардлагыг арифметик дунджаар дүгнэх бөгөөд биелэлтийн хугацаа нь дуусаагүй шаардлагуудыг хасаж тооцно.

6.10.Шаардлагын тухайн оны биелэлтийг энэ дүрмийн хавсралтад заасан аргачлалын дагуу ЭХЗХ-ны хурлаар хэлэлцэн дүгнэж, дараа жилд мөрдөх шаардлагын хамт тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүргүүлнэ.

6.11.Тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын тухайн жилд мөрдөх шаардлагыг тусгай зөвшөөрлийн цахим системд оруулна.

6.12.Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 7 дахь заалтын дагуу тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхийг дараах байдлаар үнэлнэ.

6.12.1.эрчим хүчний тухай хуулийн 12.1.1-12.1.10, 12.1.12 дахь заалтад заасан тусгай зөвшөөрлийн хувьд хүчинтэй хугацааны шаардлагын дүнгийн дунджаар тооцно,

6.12.2.эрчим хүчний тухай хуулийн 12.1.11 дэх заалтад заасан тусгай зөвшөөрлийн хувьд шаардлагын нийт заалтуудын биелэлтийн дундаж дүнгээр тооцно,

### **Долоо. Гэрчилгээ олгох**

7.1.Зөвшөөрлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 1-д заасан тусгай зөвшөөрлийн гэрчилгээг энэ дүрмийн 3.11-д заасан гэрээний биелэлтийг үндэслэн олгоно.

7.2.Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг нөхөн авахад дараах нотлох баримтыг бүрдүүлэн ЭХЗХ-нд ирүүлнэ.

7.2.1.Хүсэлт гаргасан албан бичиг,

7.2.2.Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг гээсэн, үрэгдүүлсэн, хүчингүй болох талаар өдөр тутмын сонин, хэвлэлд зарлуулсан зар мэдээллийн баримт,



7.2.3.Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ, компанийн дүрэм (нотариатаар гэрчлүүлсэн хуулбар),

7.2.4.Улсын бүртгэлийн ерөнхий газрын лавлагаа,

7.3.Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг гээсэн, үрэгдүүлсэн, гэмтээсэн, ашиглах боломжгүй шалтгаанаар нөхөн олгуулах хүсэлт гаргасан бол нотлох баримтыг үндэслэн гэрчилгээг ажлын 5 хоногийн дотор нөхөн олгож тэмдэглэл хийсэн байна.

### **Найм. Тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах**

8.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Эрчим хүчний тухай хуулийн 23.1 дэх заалтуудад заасан нөхцөл үүссэн тохиолдолд тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлтээ холбогдох баримт бичгийн хамт ЭХЗХ-нд ирүүлнэ.

8.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс энэ дүрмийн 8.1-д заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш ЭХЗХ нь 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.

8.3.Тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлтийн төрлөөс хамааруулан тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах баримт бичгийг бүрдүүлсэн байна.

8.3.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн оноосон нэрийг өөрчлөхөд:

8.3.1.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүсэлт гаргасан албан бичиг,

8.3.1.2.Тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулах үндэслэл тайлбар тэдгээртэй холбоотой бусад нотлох баримтууд,

8.3.1.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр,

8.3.1.4.Хуулийн этгээдийн өөрчлөгдөх үе болон өөрчлөгдсөний дараах үеийн дүрэм, улсын бүртгэлийн гэрчилгээ (нотариатаар батлуулсан),

8.3.1.5.Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах барилга байгууламж, шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг шилжүүлэх, барьцаалахад шаардагдах баримт бичиг,

8.3.1.6.Зээлийн болон барьцааны гэрээ,

8.3.1.7.Холбогдох бусад баримт бичиг,

8.3.2.Тусгай зөвшөөрлийн хүчин чадал нэмэх/хасахад:

8.3.2.1.Хүсэлт гаргасан албан бичиг, тайлбар, тэдгээртэй холбоотой бусад нотлох баримтууд,

8.3.2.2.Эрчим хүч үйлдвэрлэх, түгээх барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт,

8.3.2.3.Шинээр ашиглалтад орсон барилга байгууламжийн өртгийг бүртгэсэн балансын баримт бичиг,

8.3.2.4.Өөрчлөлт оруулсны дараах техник, эдийн засгийн тооцоолол,

8.3.2.5.Үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах барилга байгууламж, шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн үзүүлэлт, техникийн нөхцөл, байршил, эзэмшлийн заагийн схем зураг, танилцуулга мэдээлэл;

8.3.2.6.Холбогдох бусад баримт бичиг,

8.3.3 Тусгай зөвшөөрлийн үйлчлэх хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахад:

8.3.3.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс хүсэлт гаргасан албан бичиг, үйлчлэх хүрээндээ нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл, тайлбар, тэдгээртэй холбоотой бусад нотлох баримтууд,

8.3.3.2.Нэмэгдэх, өөрчлөгдөх барилга байгууламж, дамжуулах, түгээх шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн үзүүлэлт, техник, эдийн засгийн тооцоолол, техникийн нөхцөл, байршил, эзэмшлийн заагийн схем зураг, танилцуулга мэдээлэл,

8.3.3.3.Тухайн барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт,

